

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2018 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2018 оны 02 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт		Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
			Хугацаа	Гүйцэтгэлийн үзүүлэлт		
НЭГ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ САНАЛ, САНААЧЛАГА						
		1.1.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах.	02 дугаар сарын 05-ны дотор	-Авлигаас эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг цахим хаягт байршуулсан байх	Хяналт шалгалтын газар	
		1.1.2. Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс салбар нэгжийн Авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн, дүнг тооцох.	Улирал бүр	-Төлөвлөгөө батлагдаж, биелэлт хугацаандаа ирсэн байх -Хэрэгжүүлсэн ажлын явц, биелэтийг тухай бүр өөрийн нэгжийн болон байгууллагын цахим хаягт нийтэлсэн байх	Хяналт шалгалтын газар, Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс салбар нэгж	
		1.1.3 ШШГЕГ-ын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн ажлын явц, биелэлт, үр дүнг байгууллагын цахим хуудаст тухай бүр нийтэлж, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах.	Тухай бүр	-Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг холбогдох ШШГЕГ-ын алба, газар, хэлтэс салбар нэгжээс гаргуулан авч, цахимд мэдээллийг нийтэлсэн байх	ШШГЕГ-ын алба, газар, хэлтэс Мэдээллийн технологийн хэлтэс	
		1.2.1 Албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар сургалт зохион байгуулах, АТГ-ын Олон нийтийн төвийн сургалтад албан хаагчдыг хамруулах.	Жилдээ	-Нийт албан хаагчид сургалтад хамрагдсан байх	Хяналт шалгалтын газар Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс салбар нэгж	
		1.2.2 Ажлын байрны шаардлагыг бүрэн ханган ажиллаж байгаа алба хаагчдыг тогтвортой ажиллах, дэвших боломжоор хангаж, төрийн албаны	Жилдээ	-Алба хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр арга хэмжээ авсан байх	Хүний нөөцийн хэлтэс	

	чадахуйц /мерит/ тогтолцоог төлөвшүүлэх.				
	1.2.3. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр зайны болон танхимын давтан сургалтыг зохион байгуулах.	Жилдээ	-Эрх бүхий албан хаагчид чиглэлийн сургалтад хамрагдсан байх	ШШГЕГ-ын алба, газар, хэлтэс	
ХОЁР.ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРЭГ БОЛОН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:					
	2.3.1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Авлигатай тэмцэх газраас тараагдсан материал, гарын авлагыг албан хаагч, иргэдэд чөлөөтэй авах орчныг бүрдүүлэх.				
	2.3.2. “Та авлигагүй бүсэд нэвтэрлээ” мэдээллийн самбарыг тогтмолжуулж, иргэдэд авлигын талаар мэдээлэл авах нөхцлийг тогтмол бүрдүүлэх.				
	2.3.3. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, дүрэм, зааврыг алба хаагчдад хүргэх, танилцуулах.	Тухай бүр	- Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар иргэд, байгууллага болон албан хаагчид мэдээлэлтэй болсон байх - Сурталчилгааны материал тараагдсан байх	Хяналт шалгалтын газар, Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс салбар нэгж	
	2.4.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх журмын төслүүдийг холбогдох алба, газар, нэгжээр дамжуулан алба хаагчдад танилцуулах, хэлэлцүүлэх, санал авч, тусгах.	Тухай бүр	-Холбогдох нэгжийн санал дүрэм, журамд тодорхой хэмжээнд туссан байх	Захиргааны удирдлагын газар	

шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох	2.4.2. Нийтээр дагаж мөрдөх актын төсөлд санал авах.	Тухай бүр	-Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ шинээр боловсруулан шийдвэрийн төслийг олон нийтэд байршуулан санал авсан байх	Захиргааны удирдлагын газар	
	2.4.3. Шинээр боловсруулагдаж батлагдсан бодлогын баримт бичиг, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг цахим хуудсанд байршуулан олон нийтэд танилцуулах.	Тухай бүр	-Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байх	Захиргааны удирдлагын газар	
	2.5.1. Хяналт шалгалтын газраас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтыг хийж, дүнг цахим хуудсанд байршуулах.	Тухай бүр	-Шалгалт хийсэн байх -Хийсэн ажил, шалгалтын шийдвэрийн талаар нийтэд мэдээлсэн байх /нууцаас бусад асуудлыг/	Хяналт шалгалтын газар	
	2.5.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих анги, ШШГГ, хэлтэс салбар нэгжид санхүүгийн шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах.	Тухай бүр	-Шалгалт хийгдсэн байх -Илэрсэн зөрчил, дутагдлыг засуулсан байх	Хяналт шалгалтын газар, Санхүү хангамжийн газар, ХШҮДАХэлтэс	
	2.6.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас шийдвэр гүйцэтгэгчийн эрх олгох шалгалт авахад бүрдүүлэх материал, хаана, хэнд, хэрхэн хандах зэргийг олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр цахим хуудсанд тухай бүр байршуулах.	Тухай бүр	-Тухайн байгууллагаас олгож буй өртэй этгээдийн лавлагаа, шийдвэр гүйцэтгэгчийн эрх олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмын нээлттэй байдал хангагдсан байх	Шийдвэр гүйцэтгэх алба, Мэдээллийн технологийн хэлтэс	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.
	2.6.2 Томилогдохын өмнөх сургалтад хамрагдах иргэдэд бүрдүүлэх материал, бүртгэлийн мэдээллийг ил тод нээлттэй байдлаар цахим хуудаст байршуулах.	Тухай бүр	-Иргэдэд томилогдохын өмнөх сургалтын талаарх мэдээлэл авах орчин бүрдсэн байх	Захиргааны удирдлагын газар	Иргэдэд цахим хуудсаар мэдээлэл авах орчин бүрдэнэ.

7.	Албан хаагч бүрийн үүргийн хуваарийг тодорхой болгох	2.7.1 Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг хууль, журамд нийцүүлэх.	Тухай бүр	-Холбогдох хууль, журмын дагуу албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт батлагдаж, үр дүнгийн гэрээ байгуулагдсан байх.	Захиргааны удирдлагын газар	Албан хаагчдын ажил үүргийн хуваарь тодорхой болж, албан хаагчдын ажлын үр дүнг, холбогдох хууль, журмын хүрээнд дүгнэж, ажлын бүтээмж сайжирна
		2.7.2 Албан хаагчдын ажил, үр дүнг Төрийн албаны зөвлөлийн 134-р тогтоолыг баримтлан үнэлж, дүгнэх.	Жилдээ	-Шалгуур үзүүлэлтийг баримтлан ажил, үр дүнгийн гэрээг дүгнэсэн байх.	Захиргааны удирдлагын газар, Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс салбар нэгж	
		2.7.3 Байгууллагын бүтцийн нэгжийн ажил үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсанд тухай бүр шинэчлэн байршуулах.	Тухай бүр	-Цахим хуудсанд нээлттэй болсон байх -Албан хаагчдын ажил үүргийн хуваарь нийтэд ил тод болно.	Мэдээллийн технологийн хэлтэс	
		2.8.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-уудыг шинэчлэн томилуулж, ажлын байрны тодорхойлолтыг батлуулах.	Жилд	-Эрх бүхий албан тушаалтныг шинэчлэн томилсон байх -Гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байх -Хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт, хамгаалалтын байдал хангагдаж, нууцын баталгаа гаргуулан авсан байх	Захиргааны удирдлагын газар, Хяналт шалгалтын газар, Санхүү хангамжийн газар	
		2.8.2 Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар, нэгжийн шинээр томилогдсон эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-уудад сургалт зохион байгуулах, үүрэг, чиглэлээр хангах.	Жилдээ	-Байгууллагын хэмжээнд сургалт зохион байгуулсан байх -Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байна.	Хяналт шалгалтын газар,	
		2.9.1. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, санал, хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авч, бүртгэн мэдээллийн санд оруулж,	Жилдээ	-Гомдол, мэдээллийг хүлээн авч, бүртгэж, мэдээллийн санд оруулсан байх	Захиргааны удирдлагын газар, Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх	

<p>авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах/</p>	<p>шийдвэрлэлтийг цахим хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулах, шийдвэрлэлтэд удирдлагын зүгээс байнга хянаж, хүний зөрчигдсөн эрх, эрх чөлөөг хангаж ажиллах.</p>		<p>-Удирдлагын зүгээс байнга хянаж байх -иргэдийн зөрчигдсэн эрх хангагдсан байх</p>	<p>газар, хэлтэс салбар нэгж</p>	<p>сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт хангагдана.</p>
	<p>2.9.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад биеэр хандаж ирсэн иргэнийг угтах “Нэг цонхны үйлчилгээ”-г боловсронгуй болгох, иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, байгууллагын үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх, иргэд, олон нийтийн мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх.</p>	<p>Тухай бүр</p>	<p>-төрийн үйлчилгээ олон нийтэд чирэгдэлгүй, шуурхай хүрсэн байх</p>	<p>Захиргааны Удирдлагын газар, Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс салбар нэгж</p>	
	<p>2.9.3. Албан хаагчийн хууль бус үйлдэл, авлига, хүнд суртлын талаар бичгээр ирсэн гомдолд шалгалт хийж, шийдвэрлэж байх.</p>	<p>Тухай бүр</p>	<p>-Гомдол, мэдээллийн мөрөөр тодорхой ажил зохион байгуулсан байх -Нууц задруулсан тохиолдолд хариуцлага хүлээдэг тогтолцоонд шилжсэн байх</p>	<p>Хяналт шалгалтын газар</p>	
	<p>2.9.4.Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар цахим хуудсаар мэдээллэх.</p>	<p>Сар бүр</p>	<p>-Иргэдэд өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаарх мэдээлэл түргэн шуурхай хүрсэн байх</p>	<p>Захиргааны удирдлагын газар</p>	
	<p>2.9.5 Иргэний гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах албан тушаалтны нэр, харилцах утас, иргэнийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас, мэдээллийн самбарт тухай бүр шинэчлэн байршуулах, дүнг олон нийтэд цахим хуудсаар мэдээлэх.</p>	<p>Тухай бүр</p>	<p>-Мэдээлэл цахим хуудаст нийтлэгдэж, иргэд, олон нийт мэдээллээр хангагдсан байх</p>	<p>Захиргааны удирдлагын газар, Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс салбар нэгж</p>	
	<p>2.10.1. Албан хаагчдаас авлигын сэжигтэй тохиолдол болон авлига өгөхөөр оролдсон, санал болгосон , зуучилсан талаарх мэдээллийг тухай бүр харилцан солилцож, хамтран ажиллаж, мэдээллийг харьяаллын дагуу</p>	<p>Тухай бүр</p>	<p>-Мэдээллийг тухай бүр харилцан солилцож хамтран ажилласан байх -Мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлүүлсэн байх</p>	<p>Хяналт шалгалтын газар, Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс салбар нэгж</p>	

	шилжүүлэн шийдвэрлүүлж ажиллах.				
	2.10.2. Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс салбар, нэгжийн ЭБАТ-ууд авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, харьяа орон нутгийн захиргааны болон бусад байгууллагатай хамтран албан хаагчдад танхимийн сургалтыг зохион явуулах.	Жилдээ	-Сургалт зохион байгуулагдаж, албан хаагчдад бүрэн хамрагдсан байх -Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байх	Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс салбар нэгж	
	2.11.1. Албан хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг нэгтгэн, хуулийн хугацаанд нь Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.	3 дугаар сарын 01-ний өдрийн дотор	-Хуулийн хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлгийг хүргүүлсэн байх	Хяналт шалгалтын газар	
	2.11.2. Алба хаагчдын мэдүүлсэн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэгт хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.	Тухай бүр	-Тухай бүр мэдүүлэг гаргагчид зөрчлийг арилах талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, зөрчлийг аригалгасан байх		
	2.11.3. Шинээр томилогдсон болон их хэмжээний өөрчлөлт орсон алба хаагчдаас тухай бүр мэдүүлгийг гаргуулан авч цахим санд оруулах, түүнд хяналт тавих.	Тухай бүр	-Мэдээлэл цахимд бүрэн бүртгэгдсэн байх		
	2.12.1 Авлигай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлтэй хамтран ажиллах “Санамж бичиг”-ийг байгуулан, хамтран ажиллах	3 дугаар сарын 01-ний өдрийн дотор	-Тодорхой үйл ажиллагаа хэрэгжиж, үр дүнд хүрсэн байх	Хяналт шалгалтын газар, АТГ-ын дэргэдэх Олон нийтийн зөвлөл	
	2.12.2. Төрийн бус байгууллагатай хамтран алба хаагчдад сургалт зохион байгуулах.	Жилдээ	-Нийт албан хаагчид сургалтад хамрагдсан байх	Захиргааны удирдлагын газар, Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс салбар нэгж	

	2.12.3 Ялтныг нийгэмшүүлэх, суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, хүмүүжлийн ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрсэн байх.	Жилдээ	-Тодорхой үйл ажиллагаа хэрэгжиж, үр дүнд хүрсэн байх	Хорих ял эдлүүлэх алба	
	2.13.1 ШШГБ-ын албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, албан хаагчийн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шалган тогтоох. 2.13.2. Алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажлыг зохион байгуулах,				
	2.14.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, харьяа нэгжийн удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад тушаалыг цахим хуудсанд тухай бүр байршуулах. 2.14.2 Байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудсанд тухай бүр шинэчлэн байршуулах. 2.14.3 Үйлчлүүлэгчээс авч буй төлбөрт үйлчилгээ, төлбөр болон хураамжийг цахим хуудсанд тухай бүр шинэчлэн байршуулах.			Захиргааны удирдлагын газар, Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс салбар нэгж	
	2.15.1. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, байгууллагын зүгээс хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг сурталчлах.	Тухай бүр	-Хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны мэдээлэл олон нийтэд хүрсэн байх	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба	

	солилцох нөхцөл боломжийг сайжруулах	2.15.2. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хүрээнд төрийн байгууллага болон Арилжааны банкуудтай мэдээлэл солилцох чиглэлээр хамтран ажиллах.	Жилдээ	-Хамтран ажиллах, мэдээлэл солилцох үйл ажиллагааны хүрээг нэмэгдүүлсэн байх	Шийдвэр гүйцэтгэх алба	
		2.16.1. “Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл хяналтын систем”-ийн шинэчилсэн програм хангамжаас шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудад мэдээлэл өгөх, үйл ажиллагааг ил тод нээлттэй явуулах.	Жилдээ	-Төрийн үйлчилгээ түргэн шуурхай хүргэгдсэн байх	Шийдвэр гүйцэтгэх алба	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нээлттэй байдлыг хангасан байна
		2.16.2. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хариуцагч, нэхэмжлэгч талуудад ажиллагааны явцын талаарх мэдээллийг цахимаар өгөх программыг боловсруулж, нэвтрүүлэх.	Жилдээ	-Программыг боловсруулж, нэвтрүүлсэн байх	Мэдээллийн технологийн хэлтэс	
		2.16.3. Шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөртэй эсэх лавлагааг иргэнд цахим хэлбэрээр олгох үйл ажиллагааг нэвтрүүлэх.	Жилдээ	-Иргэд, олон нийтэд үйлчилгээ цахим хэлбэрээр хүрсэн байх	Шийдвэр гүйцэтгэх алба	
		2.16.4. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх, иргэд олон нийтийн мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх, бодит үнэн зөв мэдээллээр хангах.	Жилдээ	-Үйл ажиллагааны ил тод байдал хангагдаж, иргэд орон нийтийг мэдээллээр хангасан байх	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба	
		2.17.1. ШШГЕГ-ын үйл ажиллагаанд “Хэрэглэгчийн үнэлгээ” хийлгэх ажлыг зохион байгуулах.				
		2.17.2. Хамтран ажилладаг байгууллага, албан тушаалтан, иргэдээс хэрэглэгчийн үнэлгээний талаарх судалгааг авч, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах.				

ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ХҮРЭЭНД:						
18.	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах	3.18.1 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг цахим хуудсанд хариуцан оруулах мэдээллийн бүтэц, товыг боловсруулж мөрдүүлэх.	Багаар Тухай бүр	-Цахим хуудасны мэдээллийн сангийн тасралтгүй үйл ажиллагаа хангагдсан байх.	Захиргааны удирдагын газар, Мэдээллийн технологийн хэлтэс	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.
		3.19.1 Сул орон тооны зарыг цахим хуудсанд тухай бүр шинэчлэн байршуулах.				
		3.19.2 Хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалд нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулж, дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилох хуулийн хэрэгжилтийг хангах.				
		3.19.3 Ажилд авах, албан тушаал дэвшүүлэх, гадаад, дотоодод суралцуулах, шагнах, урамшуулах зэрэг сонгон шалгаруулах үйл ажиллагаа, журмуудыг нийтэд ил тод байлгах, оролцогч бүрийг ижил тэгш мэдээллээр хангаж, шударгаар шийдвэрлэх.			Захиргааны удирдлагын газар	
ДӨРӨВ. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ХҮРЭЭНД:						
		4.20.1. Тухайн жилд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх.	01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор			
		4.20.2 Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг цахим хуудсанд байршуулах.	4 дүгээр сарын 01-ний дотор			

		4.20.3 Дараа жилийн төсвийн төслийг цахим хуудсанд байршуулах.	8 дугаар сарын 15-ны дотор			
		4.20.4 Аудитын байгууллагын акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудсанд байршуулах.	4 дүгээр сарын 01-ний дотор			
		4.20.5. Тухайн жилд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явц, үр дүнгийн талаар ШШГЕГ-ын даргын зөвлөлд мэдээлэл хийх, салбар зөвлөлд ирүүлэх. Цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх.	Улирал бүр	-Төсөл, арга хэмжээний явц, үр дүнгийн талаар мэдээлэл бэлтгэсэн байх. -Мэдээллийг ШШГЕГ-ын даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байх -Салбар зөвлөлд ирүүлсэн байх		
		4.21.1. Бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах зарыг цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх.	Тухай бүр	-Зарыг цахим хуудсанд баршуулсан байх -Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээсэн байх. - төлөөллийг оролцуулсан байх	Санхүү хангамжийн газар	
		4.21.2 Худалдан авах үйл ажиллагааны тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх, Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухай салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах.	Тухай бүр	-Зарыг цахим хуудсанд баршуулсан байх -Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээсэн байх. - төлөөллийг оролцуулсан байх -Хүний нөөцийг ил тод байдлаар шударгаар бүрдүүлж, мэргэжлийн чадварлаг алба хаагч нар бүрэлдүүлсэн байх	Санхүү хангамжийн газар	
ТАВ.АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРААС ИРҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:						

22.	АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, зөрчил аригуулах, хариуцлага тооцуулахаар ирүүлсэн албан бичгийн хэрэгжилтийг хангах	5.22.1. ХЗДХЯ-аас ирүүлсэн Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, биелэлтийг хагас, бүтэн жилээр ХЗДХЯ-д хүргүүлэх.	Жилдээ	-Төлөвлөгөө батлагдаж, тайланг хугацаанд нь хүргүүлсэн байх -ХЗДХЯ, АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, зөрчил аригуулах, хариуцлага тооцуулахаар ирүүлсэн албан бичгийн хэрэгжилтийг хангаж, үр дүнд хүрсэн байх	ШШГЕГ-ын алба, газар, хэлтэс, Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс салбар нэгж	ХЗДХЯ, АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, зөрчил аригуулах, хариуцлага тооцуулахаар ирүүлсэн албан бичгийн хэрэгжилт хангагдсан байна.
		5.22.2. Цаашид тус газраас ирүүлсэн албан бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллах.	Тухай бүр			

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР